



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот
2023 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 заалт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах”-д хийсэн нийцлийн аудитын НТАГ-2023/12-11-НА тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын удирдлага, зохицуулалтын хэлтэс (Д.Ичин)-т үүрэг болгосугай.

3. Тайланг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал-д хүргүүлсүгэй.

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ	4
ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ	4
ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
НЭГ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ	8
ХОЁР. ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАРЛАГА БУУРУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ	9
ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ	10
ДӨРӨВ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 50 ХУВЬ БАЙНА.	12
АУДИТЫН ДҮГНЭЛТ	13
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	14
ХАВСРАЛТУУД:	15



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар



ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2024 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээ	10

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	7
Дүрслэл 2	2024 төсвийн зарлагын ангилал	9
Дүрслэл 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ангилал	10

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Малын тоо толгойн албан татварын ногдуулалтын судалгаа	15
Хавсралт 2	Зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт	15-17
Хавсралт 3	Магадлалын дүгнэлтгүй ТАХ-ний жагсаалт	17-18
Хавсралт 4	Газрын асуудал шийдвэрлэгдээгүй ТАХ-ний жагсаалт	18
Хавсралт 5	Ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй ТАХ-ний жагсаалт	19
Хавсралт 6	Нэг маягийн зураг төсөлтэй ТАХ-ний жагсаалт	20



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/04 тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2023 оны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Нийслэлийн 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх доорх асуултад хариулт өгөхөд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:
Аудитын зорилт	➢ Төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх; ➢ Төсвийн урсгал зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх; ➢ Нийслэлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж төлөвлөсөн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Нийслэлийн 2024 оны төсвийн төсөл, түүний танилцуулга, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хамруулан аудит хийв. Аудитын талбарын ажлын хүрээнд НЗДТГ, Татварын газар, Өмчийн ашиглалт, удирдлагын газар, Хөрөнгө оруулалтын газар, Автозамын хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар зэрэг байгууллагуудаас судалгаа авч дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага	Нийслэлийн Засаг дарга Нийслэлийн 2024 оны төсвийн төслийг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй. Нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлсэн Нийслэлийн 2024 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын үүрэг юм.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитыг аудитын удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, аудитын менежер Д.Ичин хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор С.Лхагвасүрэн хэрэгжүүлж, Аудитын менежер С.Гантөгс, Л.Саранбаатар, Ахлах аудитор Г.Чулуунцэцэг, М.Ундармаа нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/8472 дугаар албан бичгээр “Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад харгалзан үзэх чиглэл”-ийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсний дагуу нийслэлийн 2024 төсвийн төслийг боловсруулсан байна. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэгдэж гараагүй тул Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуультай танилцаагүй болно. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасан хугацаанд дүгнэлт гаргахад хүндрэлтэй байлаа. /Нийслэлийн 2024 оны төсвийг Нийслэлийн Засаг даргаас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн./



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын 2024 төсөвт нийслэлийн 2024 оны төсвийн суурь орлогыг 1,919.7 тэрбум төгрөг, суурь зарлагыг 1,152.1 тэрбум төгрөг, улсад төвлөрүүлэх орлогыг 230.3 тэрбум төгрөгөөр баталж, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас нийслэлд 47.8 тэрбум төгрөг хуваарилахаар тусгасан байна.

Нийслэлийн 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа татварын бүртгэлийг сайжруулах, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар орлогыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ажиллах чиглэл, зарчмыг баримталжээ.

Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 2,598.9 тэрбум төгрөгөөр төсөвлөжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 652.8 тэрбум төгрөг буюу 29.9 хувиар өссөн дүнтэй байна.

Нийслэлийн 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,351.7 тэрбум төгрөг буюу татварын болон татварын бус орлого 842.8 тэрбум, дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын шилжүүлэг 1,264.8 тэрбум, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 19.1 тэрбум төгрөг, өмнөх оны үлдэгдэл 183.1 тэрбум төгрөг, төсвийн байгууллагуудын өөрийн орлого 41.9 тэрбум төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.





НЭГ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

- 1.1. Төсвийн орлогын бүрдүүлэлтийг хот, дүүргээр нь авч үзэхэд хотын шуудын төсөвт 884.7 тэрбум төгрөгийн орлого, дүүргүүдийн төсөвт 1,714.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон байна.
 - 1.2. Улсын төсвөөс нийслэлийн төсөвт хуваарилах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийн орлогыг 690.0 тэрбум төгрөгөөр, мөн төрөөс хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, цалин хөдөлмөрийн хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.
 - 1.3. Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Багануур, Налайх, Багахангай дүүрэг хог хаягдлын үйлчилгээний хураамжаа шинэчлэн тогтоож шинэчилсэн тарифаар төсөвт төвлөрөх орлогыг 25.8 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 11.1 тэрбум төгрөгөөр нэмж төсөвт тусгасан байна.
 - 1.4. Нийслэлийн өмчийн байр талбайн ашиглалтыг сайжруулж, түрээсийн жишиг тарифыг шинэчлэн батлуулснаар нийслэлийн төсөвт төвлөрөх түрээсийн орлогыг 3.1 тэрбум төгрөг байхаар төлөвлөжээ.
 - 1.5. Нийслэл хотын албан татварын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр албан татварын хувь хэмжээг 1.0 хувиас 2.0 хувь болгон нэмэгдүүлснээр нийслэлийн төсөвт төвлөрөх Нийслэл хотын албан татварын орлогыг 32.0 тэрбум төгрөгөөр тооцож төсвийн төсөлд тусгажээ.
 - 1.6. Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1¹ авто машин угаалга, авто үйлчилгээ үзүүлэгчийг хотын албан татвараас чөлөөлөхөөр заажээ. Гэтэл “Нийслэл хотын албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төсөлд дээрх үйлчилгээнд татвар ногдуулахаар тусгасан нь хуулийн заалттай нийцэхгүй байна. Дээрх тогтоолын төслийг хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.
 - 1.7. Нийслэл дэх төрийн аудитын газраас “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар 2021-2022 онд усны нөөц ашигласны төлбөрийн орлого 9.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 3.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж алдсан гэсэн дүн гарсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар ус ашигласны төлбөрийн орлого 29 хувийн гүйцэтгэлтэй байна.
 - 1.8. Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.27-д нийцүүлэн усны нөөц ашиглагч иргэн, ААНБ-ын тоон мэдээллийг бүрэн гаргаж, зөвшөөрөл олгох эрхий бүхий байгууллага, нийслэл, дүүргийн татварын албадын ажлын уялдааг хангаж ажилласнаар ус ашигласны орлого нэмэгдэх боломж байна.
 - 1.9. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-дахь заалтад нийцүүлэн бусад дүүргийн тогтоосон дундаж хувь хэмжээгээр Баянзүрх, Хан-Уул дүүргийн мал тоо толгойн албан татварын ногдуулалтыг тооцвол 184.0 сая төгрөгөөр нийслэлийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна.
- /Хавсралт №1/*

¹ 10.1.Энэ хуулийн 7.2.1-7.2.4-т зааснаас бусад үйлчилгээг нийслэл хотын албан татвараас чөлөөлнө. 7.2.5. энэ хуулийн 4.1.8-д заасан үйлчилгээ; 7.2.6.энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээ., 4.1.8."автомашин угаалгын газар" гэж автомашины бохирдлыг цэвэрлэх иж бүрэн үйлчилгээ үзүүлэх байгууламжийг; 4.1.9."авто үйлчилгээ үзүүлэгч" гэж нийтийн тээврээс бусад авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг.




ХОЁР. ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАРЛАГА БУУРУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

2.1. Нийслэлийн 2024 оны төсвийн урсгал зардлын төслийг боловсруулахдаа төсвийг үр ашигтай, ил тод, хэмнэлттэй байх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг баримталжээ.

2.2. Нийслэлийн 2024 төсвийн нийт зарлагаас урсгал зардалд 1,109.6 тэрбум, хөрөнгийн зардалд 964.8 тэрбум, дамжуулан зээлийн эргэн төлөлтөд 85.2 тэрбум, 2 дүүрэгт санхүүгийн дэмжлэгт 7.5 тэрбум, улсын төсөвт 230.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож төлөвлөсөн байна.

2.3. Нийслэлийн 2024 төсвийн төсөлд 2024 оны 4 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмсэнтэй холбогдуулан цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг 171.5 тэрбум төгрөгөөр тусгасан нь нийт урсгал зардлын 15.5 хувийг эзэлж байна.

2.4. Нийслэлийн 2024 төсвийн зарлагыг 2,113.9 тэрбум төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар 886.9 тэрбум, замын сангийн хөрөнгөөр 77.8 тэрбум, он дамжин хэрэгжих 183.1 тэрбум нийт 1,147.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.



2.5. Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолын дагуу тэвчиж болох урсгал зардлыг (*гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, сургалт, семинар зохион байгуулахтай холбоотой зардал...гм*) 50.0 хувь хүртэл буюу дунджаар **1,409.4 сая** төгрөгөөр бууруулах боломжтой байна. Тухайлбал: Гадаад томилолтын зардалд НИТХ 750.0 сая, НЗДТГ 950.0 сая, зочин төлөөлөгч хүлээн авах зардалд НИТХ 270.0 сая, НЗДТГ 650.0 сая, Бодлогын судалгаа шинжилгээний төв ОНӨТҮГ 198.8 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн байна.



ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

3.1. Нийслэлийн 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгаж ашиглалтад оруулах, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, өмнөх жилүүдэд эхлүүлсэн төсөл арга хэмжээг хугацаанд нь дуусгах, ашиглалтад оруулах бодлогыг баримталж хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

3.2. Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,946.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 394 төсөл арга хэмжээг 1,167.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1,823.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 263 төсөл арга хэмжээ;
- Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 89.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл арга хэмжээ;
- Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих 33.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 109 төсөл арга хэмжээ.


3.3. Төсөл арга хэмжээний 707.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 118 төсөл арга хэмжээ буюу 29.9% нь 2024 онд шинээр эхлэх, 1,238.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 276 төсөл арга хэмжээ буюу 70.1% нь өмнөх онуудаас дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт 1. 2024 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээ

/сая.төг/

№	Эх үүсвэр	2024 онд шинээр эхлэх			Өмнөх онуудаас			Нийт		
		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо
1	Нийслэлийн төсөв	617,807.9	559,170.2	46	1,205,499.4	501,667.1	217	1,823,307.3	1,060,837.3	263
2	Нийслэлийн замын сан	72,386.5	72,386.5	17	16,848.1	5,473.8	5	89,234.6	77,860.3	22
3	Нийслэлийн ОНХС	17,792.4	17,792.4	55	16,111.9	10,524.2	54	33,904.3	28,316.6	109
НИЙТ		707,986.8	649,349.1	118	1,238,459.4	517,665.1	276	1,946,446.2	1,167,014.2	394

3.4. Төсөл арга хэмжээг зориулалтаар нь ангилбал 46.6% нь барилга байгууламж, 12% нь зураг төсөл болон зөвлөх үйлчилгээ, 6.0% нь тохижилт, 6.0% нь их засвар, 10.0% нь дэд бүтцийн ажил, 8.0% нь техник, тоног төхөөрөмж, программ хангамж, 8.0% нь газар чөлөөлөлтийн ажил, 3.0% нь парк шинэчлэлт, 0.4% нь бусад ажлууд байна.





3.5. Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгасан байна. /шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 707,986.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 118 ТАХ/ Үүнд:

- ТАХ-ээс 77 буюу 65.2%-д нь зураг, төсөл шаардагдах ТАХ байна. Үүнээс 19 буюу 24.6% нь зураг төсөвтэй, 58 буюу 75.3% зураг төсөвгүй байна. /Хавсралт №2/

- Зураг төсөвт магадлал хийлгээгүй 36 ТАХ Хавсралт 3, газрын зөвшөөрөлгүй 8 ТАХ байна. /Хавсралт №4/

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-т заасан “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3. “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” заалтыг зөрчиж байна.

- Төсвийн тухай хуулийн 29.3.4-т заасан “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасан ч ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй 33 ТАХ байна. /Хавсралт №5/

- Төсөл арга хэмжээ иж бүрэн бус /нэг маягийн зураг төсөлтэй/ холболтын зураг төсөлтэй 12 ТАХ байна. /Хавсралт №6/

Энэ нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.17-д заасан “Магадлал хийж баталгаажсан зураг төслийг болон барилга байгууламжийн нэг маягийн зургийг давтан хэрэглэх тохиолдолд ажлын зурагт өөрчлөлт орсон хэсэгт магадлал хийлгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна. Нэг маягийн зураг төсөлтэй ТАХ-нд холболтын зураг төслийн төсөв нэмэгдэж, төсөвт өртөг нэмэгдэх, үүнээс ТАХ цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

3.6. Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө газрын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, магадлалаар баталгаажсан төсөвтөө байх, эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгаа хийгдсэн байх зэрэг төсвийн шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгах шаардлагатай байна.



ДӨРӨВ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 50 ХУВЬ БАЙНА.

4.1. Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар НИТХ-д 2 Нийслэлийн Засаг даргад 4 зөвлөмж хүргүүлснээс Нийслэлийн Засаг даргад өгсөн 3 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжилт хангалтгүй, НИТХ-д өгсөн 2 зөвлөмж хэрэгжээгүй гүйцэтгэл 50 хувьтай байна.

4.2. ҮХЭХАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу НИТХ-ын 2012 оны 5/18 дугаар тогтоолоор баталсан татварын хэмжээг шинэчлэн батлах, Баянзүрх, Хан-Уул дүүргийн ИТХ-аас Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох талаар өгсөн 2 зөвлөмжийг НИТХ хэрэгжүүлээгүй байна.

4.3. Нийслэлийн Засаг даргад өгсөн “Нийслэл, дүүргийн төсвийг төлөвлөхдөө эдийн засгийн онолын судалгаа, шинжилгээний тохирох загваруудыг ашиглан төсвийн орлого, зардалд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарал, нөлөөлөл зэргийг тооцож байх” зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. “Нийслэл хотын албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төсөл нь Нийслэл хотын албан татварын тухай хуулийн заалттай нийцэхгүй байна.
2. Нийслэлийн 2024 оны төсвийн орлогыг 2,598.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх онтой харьцуулахад 652.8 тэрбум төгрөг буюу 29.9 хувиар өссөн байна.
3. Нийслэлийн 2024 оны төсвийн нийт зардлыг 2.113,9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оноос 836.0 тэрбум төгрөг буюу 39.5 хувиар өссөн нь цалин, хөлс нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.
4. Нийслэлийн 2024 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлалд агуулгаараа нийцэж байна.
5. Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан 118 ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүн нь Төсвийн тухайн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5²-д заасан шаардлагыг хангасан байна.
6. Хэрэгжүүлэх ажлын жагсаалтад зураг төсөвгүй 58, газрын асуудал шийдвэрлэгдээгүй 8, зураг төсөвт магадлал хийлгээгүй 36, ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй 33, нэг маягийн зураг төсөлтэй 12 ТАХ-г тусгасан нь хуульд тогтоомжид заасан шаардлага хангахгүй байна.
7. Нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцооллыг ирүүлээгүй нь төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

² 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

- Нийслэлийн 2024 төсвийн төсөлд Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан шаардлага хангасан төсөл арга хэмжээг батлах;
- “Нийслэл хотын албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төслийг Нийслэл хотын албан татварын тухай хуульд нийцүүлэх;

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29, 29¹ дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх;
- Төсвийн төсөлд төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын болон хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцооллууд, нотлох баримтаар баталгаажсан холбогдох баримт бичгүүдийг ирүүлж байх;



ХАВСРАЛТУУД:

Хавсралт №1

Малын тоо толгойн албан татварын ногдуулалтын судалгаа

№	Дүүрэг	2023 оны жилийн эцсийн малын тоо	2023 оны төсвийн төсөлд тусгах дүн /сая.төг/	Тайлбар
1	Баянзүрх	67,886	107.2	Малын тоо, толгойн албан татварын тухай хууль батлагдсанаас хойш татвар ногдуулаагүй . Бусад дүүргийн тогтоосон дундаж хувь хэмжээгээр тооцсон.
2	Хан-Уул	46,068	76.8	Малын тоо, толгойн албан татварын тухай хууль батлагдсанаас хойш татвар ногдуулаагүй . Бусад дүүргийн тогтоосон дундаж хувь хэмжээгээр тооцсон.
Дүн			184.0	

Хавсралт №2

Зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт

							/сая.төг/
№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих	Төсөл, арга хэмжээний ангилал	
1	Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудалтай (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо, 127 дугаар сургууль)	2024	2026	6,500.00	1,950.00	Барилга байгууламж	
2	23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий спорт заал шинээр барих (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2025	7,400.00	2,220.00	Барилга байгууламж	
3	49 дүгээр сургуулийн спорт заалыг бассейн бүхий спорт заал шинээр барих (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2025	7,401.00	2,220.30	Барилга байгууламж	
4	Нийслэлийн ерөнхий боловсролын 22 дугаар сургуулийн баруун, зүүн талын тохижилтын ажил (БГД, 17 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт	
5	Гэр хорооллын гудамж, талбай хусаж, тэгшлэх ажил (БЗД, 2, 4, 21, 27, 29 дүгээр хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт	
6	Амьдрах орчин сайжруулах (БЗД, 2 дугаар хороо)	2024	2024	200.00	200.00	Тохижилт	
7	Гэрэлтүүлгийн ажил (БЗД, 30 дугаар хороо)	2024	2024	200.00	200.00	Тохижилт	
8	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (БЗД, 11 дүгээр хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт	
9	Спорт талбай тохижуулах ажил (БЗД, 25 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт	
10	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (БЗД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт	
11	Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах ажил (БЗД)	2024	2024	400.00	400.00	Их засвар	
12	Гэрэлтүүлгийн ажил (БЗД, 9, 28 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт	
13	Сэнгүр горхи хотхоны зам засварын ажил (БЗД, 41 дүгээр хороо)	2024	2024	250.00	250.00	Их засвар	
14	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт (БЗД)	2024	2024	30.00	30.00	Тохижилт	
15	Гэрэлтүүлгийн ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20, 33 дугаар хороо)	2024	2024	2,223.00	2,223.00	Барилга байгууламж	
16	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	2024	2024	6,000.00	6,000.00	Барилга байгууламж	
17	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	2024	2024	3,600.00	3,600.00	Барилга байгууламж	
18	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	2024	2024	6,000.00	6,000.00	Барилга байгууламж	
19	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	2024	2024	2,400.00	2,400.00	Барилга байгууламж	
20	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2024	2,400.00	2,400.00	Барилга байгууламж	



21	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Багануур дүүрэг)	2024	2024	1,200.00	1,200.00	Барилга байгууламж
22	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)	2024	2024	600.00	600.00	Барилга байгууламж
23	Багахангай дүүргийн авто замын засвар	2024	2024	150.00	150.00	Их засвар
24	Налайх дүүргийн авто замын засвар	2024	2024	500.00	500.00	Их засвар
25	Гүүр, хоолой, түннелийн засварын ажил	2024	2024	1,000.00	1,000.00	Их засвар
26	Нийтийн тээврийн хэрэгслийн тусгай эгнээний өнгөт хучилт	2024	2024	3,000.00	3,000.00	Их засвар
27	Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар арчлалт болон гэрлэн дохио шинээр суурилуулах	2024	2024	1,000.00	1,000.00	Их засвар
28	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчиход ээлтэй орчин бүрдүүлэх ажил	2024	2024	500.00	500.00	Их засвар
29	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил (НД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
30	Нарлагийн хэсгийн голын замын шинэчлэлийн ажил (НД, 8 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Их засвар
31	БУСАД	2024	2024	1,792.40	1,792.40	бусад
32	Боловсролын салбарын барилгын их засвар (Улаанбаатар хот)	2024	2024	3,000.00	3,000.00	Их засвар
33	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын засварын ажил (Улаанбаатар хот)	2024	2024	4,500.00	4,500.00	Их засвар
34	Улаанхуарангийн авто замаас Улиастайн замтай холбогдох авто замын ажил, 2.83 км (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8, 10, 38 дугаар хороо)	2024	2025	5,945.00	2,972.50	Барилга байгууламж
35	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооноос 18 дугаар хороог холбосон авто замын ажил (ЧД, 14, 18 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Барилга байгууламж
36	Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 10, 16 хороо, Яармаг орчмын нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон хотхонуудад хэрэглэгдэж буй цэвэр усны шугамын шинэчлэлт (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4, 5, 6, 7, 10, 16 хороо)	2024	2024	6,000.00	6,000.00	Барилга байгууламж
37	Бүтээн байгуулалт, тохижилтын ажил (БГД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
38	Бүтээн байгуулалт, тохижилтын ажил (БГД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
39	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил (БГД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
40	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засвар шинэчлэлт (СБД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
41	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (СБД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
42	Гэрэлтүүлгийн ажил (СБД, 12, 15, 17 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
43	Гэр хороолол дундах зам түрж тэгшлэх ажил (СБД, 15, 16, 18 дугаар хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
44	Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажил	2024	2024	1,500.00	1,500.00	Их засвар
45	Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажил	2024	2024	1,000.00	1,000.00	Их засвар
46	Хаппи таун хотхон 69 дүгээр сургуулийн дунд зам талбайн тохижилт (БЗД, 5 дугаар хороо)	2024	2024	70.00	70.00	Тохижилт
47	Баянзүрх худалдааны төвийн баруун талд явган хүний замын тохижилт (БЗД, 40 дүгээр хороо)	2024	2024	50.00	50.00	Тохижилт
48	Гэрэлтүүлэг, камержуулалтын ажил (БЗД, 19, 22, 31, 32, 40 дүгээр хороо)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
49	Спорт талбай тохижуулах ажил (СХД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
50	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	2024	2024	400.00	400.00	Тохижилт
51	Тохижилт, ногоон байгууламжийн ажил (БХД, 1, 2 дугаар хороо)	2024	2024	80.00	80.00	Тохижилт
52	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	2024	2024	1,200.00	1,200.00	Барилга байгууламж
53	Тээврийн хэрэгслийн зогсоолыг стандартад нийцүүлж, зогсоолын менежментийг сайжруулах (Улаанбаатар хот)	2024	2024	6,500.00	6,500.00	Барилга байгууламж
54	Хотын гол болон туслах гудамж замуудын засвар, шинэчлэлт болон авто зам, замын байгууламжийг шинээр барих	2024	2024	37,236.50	37,236.50	Их засвар
55	Хотын гол болон туслах гудамж замуудын арчлалт, засварын ажил	2024	2024	18,000.00	18,000.00	Их засвар
56	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын ажил	2024	2024	1,000.00	1,000.00	Их засвар



57	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил	2024	2024	5,000.00	5,000.00	Их засвар
58	Багануур дүүргийн авто замын засвар	2024	2024	500.00	500.00	Их засвар
Нийт				153,927.90	136,044.70	

Хавсралт №3

Магадлалын дүгнэлтгүй ТАХ-ний жагсаалт

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих	Төсөл, арга хэмжээний ангилал
1	Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо)	2024	2026	18,000.0	5,000.0	Барилга байгууламж
2	Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудалтай (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо, 127 дугаар сургууль)	2024	2026	6,500.0	1,950.0	Барилга байгууламж
3	Сургуулийн барилга буулгаж шинээр барих, 960 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 30 дугаар сургууль)	2024	2026	16,700.0	5,010.0	Барилга байгууламж
4	23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий спорт заал шинээр барих (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2025	7,400.0	2,220.0	Барилга байгууламж
5	49 дүгээр сургуулийн спорт заалыг бассейн бүхий спорт заал шинээр барих (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2025	7,401.0	2,220.3	Барилга байгууламж
6	Гэрэлтүүлгийн ажил (БЗД, 30 дугаар хороо)	2024	2024	200.0	200.0	Тохижилт
7	Спорт талбай тохижуулах ажил (БЗД, 25 дугаар хороо)	2024	2024	400.0	400.0	Тохижилт
8	Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах ажил (БЗД)	2024	2024	400.0	400.0	Их засвар
9	Гэрэлтүүлгийн ажил (БЗД, 9, 28 дугаар хороо)	2024	2024	400.0	400.0	Тохижилт
10	Сэнгүр горхи хотхоны зам засварын ажил (БЗД, 41 дүгээр хороо)	2024	2024	250.0	250.0	Их засвар
11	Гэрэлтүүлгийн ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20, 33 дугаар хороо)	2024	2024	2,223.0	2,223.0	Барилга байгууламж
12	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	2024	2024	6,000.0	6,000.0	Барилга байгууламж
13	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	2024	2024	3,600.0	3,600.0	Барилга байгууламж
14	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	2024	2024	6,000.0	6,000.0	Барилга байгууламж
15	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	2024	2024	2,400.0	2,400.0	Барилга байгууламж
16	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2024	2,400.0	2,400.0	Барилга байгууламж
17	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Багануур дүүрэг)	2024	2024	1,200.0	1,200.0	Барилга байгууламж
18	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)	2024	2024	600.0	600.0	Барилга байгууламж
19	Өрхийн эмнэлгийн барилга (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо)	2024	2024	2,000.0	2,000.0	Барилга байгууламж
20	Хорооны өргөтгөлийн барилга (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо)	2024	2024	3,000.0	3,000.0	Барилга байгууламж
21	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо)	2024	2025	2,800.0	2,800.0	Барилга байгууламж
22	Улаанхуарангийн авто замаас Улиастайн замтай холбогдох авто замын ажил, 2.83 км (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8, 10, 38 дугаар хороо)	2024	2025	5,945.0	2,972.5	Барилга байгууламж
23	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооноос 18 дугаар хороог холбосон авто замын ажил (ЧД, 14, 18 дугаар хороо)	2024	2024	400.0	400.0	Барилга байгууламж
24	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж



25	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39 дүгээр хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
26	Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 10, 16 хороо, Яармаг орчмын нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон хотхонуудад хэрэглэгдэж буй цэвэр усны шугамын шинэчлэлт (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4, 5, 6, 7, 10, 16 хороо)	2024	2024	6,000.0	6,000.0	Барилга байгууламж
27	Гэрэлтүүлгийн ажил (СБД, 12, 15, 17 дугаар хороо)	2024	2024	400.0	400.0	Тохижилт
28	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
29	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
30	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
31	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
32	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
33	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
34	Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажил	2024	2024	1,000.0	1,000.0	Их засвар
35	Гэрэлтүүлэг, камержуулалтын ажил (БЗД, 19, 22, 31, 32, 40 дүгээр хороо)	2024	2024	400.0	400.0	Тохижилт
36	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	2024	2024	1,200.0	1,200.0	Барилга байгууламж
	Нийт			131,619.0	75,845.8	

Хавсралт №4

Газрын асуудал шийдвэрлэгдээгүй ТАХ-ний жагсаалт

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих	Төсөл, арга хэмжээний ангилал
1	Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо)	2024	2026	18,000.0	5,000.0	Барилга байгууламж
2	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо)	2024	2025	2,800.0	2,800.0	Барилга байгууламж
3	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
4	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39 дүгээр хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
5	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
6	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
7	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
8	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0	Барилга байгууламж
	Нийт			40,600.0	17,700.0	



Хавсралт №5

Ерөнхий нэрээр баталсан, нэр, байршил нь тодорхойгүй ТАХ-ний жагсаалт

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих
1	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (БЗД)	2024	2024	400.0	400.0
2	Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах ажил (БЗД)	2024	2024	400.0	400.0
3	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт (БЗД)	2024	2024	30.0	30.0
4	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	2024	2024	6,000.0	6,000.0
5	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	2024	2024	3,600.0	3,600.0
6	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг)	2024	2024	6,000.0	6,000.0
7	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)	2024	2024	2,400.0	2,400.0
8	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг)	2024	2024	2,400.0	2,400.0
9	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Багануур дүүрэг)	2024	2024	1,200.0	1,200.0
10	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)	2024	2024	600.0	600.0
11	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил (НД)	2024	2024	400.0	400.0
12	Бусад	2024	2024	1,792.4	1,792.4
13	Боловсролын салбарын барилгын их засвар (Улаанбаатар хот)	2024	2024	3,000.0	3,000.0
14	Улаанхуарангийн авто замаас Улиастайн замтай холбогдох авто замын ажил, 2.83 км (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8, 10, 38 дугаар хороо)	2024	2025	5,945.0	2,972.5
15	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	2024	2024	400.0	400.0
16	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэл, камержуулалт (СХД)	2024	2024	400.0	400.0
17	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил (ЧД)	2024	2024	800.0	800.0
18	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (ЧД)	2024	2024	400.0	400.0
19	Бүтээн байгуулалт, тохижилтын ажил (БГД)	2024	2024	400.0	400.0
20	Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж (БГД)	2024	2024	400.0	400.0
21	Бүтээн байгуулалт, тохижилтын ажил (БГД)	2024	2024	400.0	400.0
22	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил (БГД)	2024	2024	400.0	400.0
23	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	2024	2024	400.0	400.0
24	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	2024	2024	400.0	400.0
25	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засвар шинэчлэлт (СБД)	2024	2024	400.0	400.0
26	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (СБД)	2024	2024	400.0	400.0
27	Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын ажил (СХД)	2024	2024	400.0	400.0
28	Спорт талбай тохижуулах ажил (СХД)	2024	2024	400.0	400.0
29	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж, засвар шинэчлэлт (СХД)	2024	2024	400.0	400.0
30	Сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж (СХД)	2024	2024	400.0	400.0
31	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	2024	2024	400.0	400.0
32	Сургууль, цэцэрлэгийн камержуулалт (СХД)	2024	2024	400.0	400.0
33	Нийслэлд хэрэгжүүлэх тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (Улаанбаатар хот, Налайх дүүрэг)	2024	2024	1,200.0	1,200.0
	Нийт			42,967.4	39,994.9



Хавсралт №6

Нэг маягийн зураг төсөлтэй ТАХ-ний жагсаалт

/сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих
1	Өрхийн эмнэлгийн барилга (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо)	2024	2024	2,000.0	2,000.0
2	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо)	2024	2025	2,800.0	2,800.0
3	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
4	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39 дүгээр хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
5	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
6	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
7	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
8	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
9	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
10	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо)	2024	2025	3,300.0	1,650.0
11	Сургуулийн барилга, 960 суудал (Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо)	2024	2026	18,000.0	5,000.0
12	Сургуулийн барилга буулгаж шинээр барих, 960 суудал (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 30 дугаар сургууль)	2024	2026	16,700.0	5,010.0
	Нийт			65,900.0	28,010.0